



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний яамны харьяа “Тавантолгойн цахилгаан станц” төслийн нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 225,000,000.00 (хоёр зуун хорин таван сая) төгрөгийн балансын үнэ, 37,500,000.00 (гучин долоон сая таван зуун мянган) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” төрийн өмчит үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, “Тавантолгойн цахилгаан станц” төслийн захирал Д.Батбилэг, “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал М.Түмэнжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮИНХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Э.ЭРДЭНЭХИШИГ

000150

D:\Huraldaanii material\2018 он\2018.04.03\06docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 04 дүгээр сарын 03 -ны өдрийн
...дугаар тогтоолын хавсралт

Эрчим хүчний яамны харьяа "Тавантолгойн цахилгаан станц" төслийн нэгжийн балансаас
"Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" төрийн өмчит үйлдвэрийн газрын балансад шилжүүлэх хөрөнгө

Д/д	Автомашины төрөл, зориулалт, улсын дугаар	Ашиглалтанд орсон он	Нийт гүйлт /км/	Нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	"Тоёота Ландкруйзер-200", суудлын, 14-45 УНҮ	2016	0	225,000,000.00	37,500,000.00	187,500,000.00
НИЙТ ДҮН:				225,000,000.00 (хоёр зуун хорин таван сая)	37,500,000.00 (гучин долоон сая таван зуун мянган)	187,500,000.00 (нэг зуун наян долоон сая таван зуун мянган)